

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/57/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	2
Аудитын гол асуудал	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХБАЯР ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Б.Мөнхбаяр № *65*

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хонгор сумын ИТХ нь “Монголын цахилгаан холбоо” ХК-тай хамтран хүүхэд хамгааллын жилийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн бага насны хүүхдүүдийг аливаа эрсдлээс сэргийлэх аюулгүй байдлыг хангах зорилготой “Итгэлтэй утас”-ыг байрлуулсан Итгэлтэй утас”-аар нэг дуудлагаар 2 минут хүртэлх хугацаатай сард 2000-2500 минутын дуудлага хийгдэх боломжтой бөгөөд сурагчид бүх сүлжээнд гар утасны нэгж, цэнэг дуусах, сүлжээ тасрах гэх асуудалгүйгээр гэр бүлийн гишүүдтэйгээ үнэгүй холбоо барим боломжтой болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 271,284.8 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн нь орон нутгийн нэмэгдэл 60 хувь, улсын төсвөөс өгсөн орон нутгийн нэмэгдэл 40 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 бүлэг 13 зорилтын хүрээнд 92 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.5 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/


Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,621,300.00	3,066,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,621,300.00	3,066,300.00
354	Хангамжийн материал	3,621,300.00	3,066,300.00
35410	Бичиг хэргийн материал	68,600.00	68,600.00
35440	Аж ахуйн материал	555,000.00	
35470	Бусад хангамжийн материал	2,997,700.00	2,997,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,657,799.61	19,921,742.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,657,799.61	19,921,742.60
392	Биет хөрөнгө	27,983,219.61	19,472,022.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,166,667.00	21,166,667.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,166,667.28)	(21,166,667.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,659,380.00	27,714,380.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,439,805.18)	(13,667,142.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,129,574.00	13,713,574.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,365,931.53)	(9,788,790.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,000,005.00	6,000,005.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,000,002.40)	(4,500,003.60)
393	Биет бус хөрөнгө	674,580.00	449,720.04
39301	Программ хангамж	674,580.00	674,580.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(224,859.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	32,279,099.61	22,988,042.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,279,099.61	22,988,042.60
51	Засгийн газрын хувь оролцоо	32,279,099.61	22,988,042.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,118,486.00	9,118,486.00
512	Хуримтлагдсан үр дүн	23,160,613.61	13,869,556.60
51210	Өмнөх үеийн үр дүн	23,160,613.61	23,160,613.61
51220	Тайлант үеийн үр дүн		(9,291,057.01)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	32,279,099.61	22,988,042.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	253,668,860.00	433,890,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,670,460.00	
120	Нийтлэг татварын бус орлого	7,670,460.00	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	7,670,460.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,998,400.00	433,890,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,600,000.00	14,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,600,000.00	14,400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,398,400.00	419,490,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,398,400.00	419,490,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	262,011,531.15	443,181,557.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,011,531.15	443,181,557.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,090,759.97	271,284,808.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,397,025.22	374,274,324.44
210101	Үндсэн цалин	71,405,216.09	110,818,483.10
210102	Нэмэгдэл	32,486,105.00	117,915,429.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,290,000.00	10,630,000.00
210104	Урамшуулал	27,215,704.13	31,920,896.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,300,516.60	32,615,421.45
210201	Тэтгэврийн даатгал	10,932,616.60	21,662,721.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,000.00	2,783,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,073,700.00	1,389,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	268,400.00	1,389,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,683,800.00	5,390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,280,460.00	18,778,310.00
210401	Бичиг хэрэг	5,785,210.00	5,977,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,986,500.00	11,310,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		39,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,508,750.00	1,450,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,952,000.00	3,676,000.00
210604	Урсгал засвар	5,952,000.00	3,676,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,452,600.00	3,085,000.00
210702	Дотоод албан томилолт	1,452,600.00	3,085,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,366,537.00	19,170,437.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,150,000.00	18,164,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,000.00	840,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,737.00	54,837.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	183,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,341,621.15	25,664,347.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,659,719.00	7,421,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,150,000.00	3,867,640.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,531,902.15	14,375,057.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,920,771.18	68,907,232.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,854,000.00	23,956,326.50
213208	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	12,870,000.00
	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	9,466,326.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,854,000.00	1,854,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,066,771.18	17,950,906.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,917,971.18	17,950,906.07
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	148,800.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(8,342,671.15)	(9,291,057.01)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,342,671.15)	(9,291,057.01)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	245,998,400.00	433,890,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,998,400.00	433,890,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,600,000.00	14,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,600,000.00	14,400,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,398,400.00	419,490,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,398,400.00	419,490,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	238,919,100.00	428,251,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,919,100.00	428,251,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,998,328.82	359,344,267.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,397,025.22	271,284,808.98
210101	Үндсэн цалин	71,405,216.09	110,818,483.10
210102	Нэмэгдэл	32,486,105.00	117,915,429.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,290,000.00	10,630,000.00
210104	Урамшуулал	27,215,704.13	31,920,896.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,300,516.60	32,615,421.45
210201	Тэтгэврийн даатгал	10,932,616.60	21,662,721.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,000.00	2,783,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,073,700.00	1,389,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	268,400.00	1,389,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,683,800.00	5,390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,047,200.00	21,907,810.00
210401	Бичиг хэрэг	5,491,750.00	6,554,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,541,500.00	12,965,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		39,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,013,950.00	2,348,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,952,000.00	3,676,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	5,952,000.00	3,676,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,452,600.00	3,085,000.00
210702	Дотоод албан томилолт	1,452,600.00	3,085,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,366,537.00	18,140,737.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,150,000.00	17,134,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,000.00	840,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,737.00	54,837.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	183,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,482,450.00	8,634,490.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,332,450.00	4,766,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,150,000.00	3,867,640.00



213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,920,771.18	68,907,232.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,854,000.00	23,956,326.50
213208	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	12,870,000.00
	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	9,466,326.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,854,000.00	1,620,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,066,771.18	17,950,906.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,917,971.18	17,950,906.07
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	148,800.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,079,300.00	5,639,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,079,300.00	5,639,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,079,300.00	5,639,000.00
225106	Дотоод эх үүсвэрээр	7,079,300.00	5,639,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	7,079,300.00	(5,639,000.00)



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,118,486.00		31,503,284.76	40,621,770.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-8,342,671.15	-8,342,671.15
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,118,486.00		23,160,613.61	23,160,613.61
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,118,486.00		23,160,613.61	23,160,613.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,291,057.01)	(9,291,057.01)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,118,486.00		13,869,556.60	22,988,042.60



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,490,500.00	433,890,500.00	14,400,000.00	103%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,490,500.00	428,251,500.00	8,761,000.00	102%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	368,388,500.00	359,344,267.43	(9,044,232.57)	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,350,200.00	271,284,808.98	(7,065,391.02)	97%
210101	Үндсэн цалин	111,445,000.00	110,818,483.10	(626,516.90)	99%
210102	Нэмэгдэл	120,785,200.00	117,915,429.70	(2,869,770.30)	98%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	10,630,000.00	(1,970,000.00)	84%
210104	Урамшуулал	33,520,000.00	31,920,896.18	(1,599,103.82)	95%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,793,800.00	32,615,421.45	(2,178,378.55)	94%
210201	Тэтгэврийн даатгал	23,659,600.00	21,662,721.45	(1,996,878.55)	92%
210202	Тэтгэмжийн даатгал	2,783,500.00	2,783,500.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,391,800.00	1,389,600.00	(2,200.00)	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,391,800.00	1,389,600.00	(2,200.00)	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,567,100.00	5,390,000.00	(177,100.00)	97%
2104	Хангамж, бараа материалын зардал	16,190,000.00	21,907,810.00	5,717,810.00	135%
210401	Бичиг хэрэг	3,400,000.00	6,554,200.00	3,154,200.00	193%
210402	Тээвэр, шатахуун	10,265,000.00	12,965,200.00	2,700,200.00	126%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	744,000.00	39,710.00	(704,290.00)	5%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,781,000.00	2,348,700.00	567,700.00	132%
2105	Нормативт зардал	-	-	-	0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,600,000.00	3,676,000.00	(1,924,000.00)	66%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00		(1,800,000.00)	0%
210604	Урсгал засвар	3,800,000.00	3,676,000.00	(124,000.00)	97%
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	3,085,000.00	(915,000.00)	77%
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,085,000.00	(915,000.00)	77%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,644,500.00	18,140,737.00	(4,503,763.00)	80%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,585,500.00	17,134,800.00	(4,450,700.00)	79%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	840,000.00	840,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	89,100.00	(10,900.00)	89%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,000.00	54,837.00	(39,163.00)	58%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00	(3,000.00)	88%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,810,000.00	8,634,490.00	1,824,490.00	127%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,810,000.00	4,766,850.00	(43,150.00)	99%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	3,867,640.00	1,867,640.00	193%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,102,000.00	68,907,232.57	17,805,232.57	135%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00	-	100%
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	27,000,000.00	27,000,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,102,000.00	23,956,326.50	(145,673.50)	99%




213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	-	100%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	9,466,326.50	(115,673.50)	99%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	1,620,000.00	(30,000.00)	98%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох			-	0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,639,000.00	5,639,000.00	0%
	Дотоод эх үүсвэрээр	-	5,639,000.00	5,639,000.00	0%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	419,490,500.00	401,539,593.93	(17,950,906.07)	96%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	419,490,500.00	401,539,593.93	(17,950,906.07)	96%
1	Төсвийн бусад мэдээллийн ангилал				0%
2	Байгууллагын тоо				0%
5	Ажиллагсдын тоо	7.00	6.00	1.00	86%
6	Удирдах ажилтан	1.00	1.00		100%
7	Гүйцэтгэх ажилтан	4.00	3.00	1.00	75%
8	Үйлчлэх ажилтан				0%
9	Гэрээт ажилтан	2.00	2.00		100%
24	Орон тооны мэдээлэл				



2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.00
210104	Урамшуулал	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,760,000.00	5,760,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,447,900.00	1,447,900.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,700,200.00	2,700,200.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,611,900.00	1,611,900.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,040,000.00	3,040,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,040,000.00	3,040,000.00	0.00	100.00
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,400,000.00	14,400,000.00	0.00	100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	0.00	0.00



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хонгор сумын ИТХ нь “Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэн нутгийн удирдлагын нэмэгдэл байдлыг хангаж, иргэдийн идэвх оролцоонд тулгуурлан, орон нутгийн хөгжлийн бодлого, чиг хандлагыг оновчтой тодорхойлох, эдийн засаг нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэхэд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрхэм зорилго оршино” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ” зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын ИТХ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Хонгор сумын ИТХ-ийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС болон СТОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,291.09 мянган төгрөг болж 28.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-		-
Бараа материал	3,621.30	3,066.30	(555.00)
Үндсэн хөрөнгө	28,657.79	19,921.74	(8,736.05)
Нийт хөрөнгө	32,279.09	22,988.00	(9,291.09)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,118.48	9,118.48	-
Хуримтлагдсан үр дүн	23,160.61	13,869.52	(9,291.09)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	32,279.09	22,988.00	(9,291.09)

Бараа материалын дансны үлдэгдэл 3,066.3 мянган төгрөг болж өмнөх оноос 555.00 буурсан 41,430.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 41,985.6 мянган төгрөгийн зарцуулалт гарсантай холбоотой.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 19,921.74 мянган төгрөг болж 8,736.05 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,639.0 мянган төгрөг үндсэн хөрөнгө худалдан авч, хуримтлагдсан элэгдэл 34,972.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,988.0 мянган төгрөг болж 9,291.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 308,635.2 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд нийт батлагдсан төсвийг 419,490.5 мянган төгрөг болж 110,855.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийг нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 81,444.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 10,179.9 мянган төгрөг, сонгуулийн өмнө чөлөөлөгдсөн албан хаагчид нөхөн төлбөр 12,870.0 мянган төгрөгийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 419,490.5 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 419,490.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 401,539.6 мянган төгрөгийг зарцуулж, 17,950.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401,539.6 мянган төгрөг буюу 95,72 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 17,950.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70105-ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага					
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	328,178.50	313,415.30	(14,763.20)	95.50	
1.2	80825-Багийн ИНХ-ын даргын урамшуулал	16,326.50	13,518.20	(2,808.30)	82.80	
1.3	80111-Төрийн өмчийн тогтмол зардал	3,800.00	3,676.00	(124.00)	96.74	
1.4	81505-ИТХ-д суудалтай намуудад олгох	27,000.00	27,000.00	-	100.00	
1.5	80802-Ажил олгогчоос тэтгэмж урамшуулал	11,232.00	11,086.30	(145.70)	98.70	
1.6	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийл	20,000.00	19,973.80	(26.20)	99.87	
1.7	Мэдээлэл, сурталчилгааны зардал	83.50	-	(83.50)	-	
1.8	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	12,870.00	12,870.00	-	100.00	
2.2	Нийт дүн	419,490.50	401,539.60	(17,950.90)	95.72	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус байгууллага нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 4 ажилтан, үйлчлэх 3 ажилтан буюу нийт 8 ажилтантайгаар ажиллаж, 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 22,195.7 мянган төгрөг, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 5,594.5 мянган төгрөгийг зарцуулж, Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 14,400.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 262,011.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,620.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 255.3 мянган төгрөгийн 1 актын биелэлтийг шалгахад зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	255.3	1	255.3	100
Нийт дүн	1	255.3	1	255.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Тайлангийн 4.4.2-т дурдсан Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Албан тушаалтны тоо			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-